



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 24

Арвайхээр

Салбар комисс байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2,5, 6, 7 дугаар дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Ганболд -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Салбар зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга: Э.Бадамгэрэл -Төрийн захиргааны удирдлагын  
хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан  
ахлах мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн  
бичгийн дарга

Гишүүд: Б.Сайнжаргад -Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Салбар  
зөвлөлийн гишүүн


Т.Чинзориг –Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга,  
Салбар зөвлөлийн гишүүн

Т.Үржинпүрэв –Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн  
дарга

2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг цахимаар хийж, шалгалт авах байр, компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг Салбар комиссын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүнг 2018 оны 12 дугаар сарын 26-ны дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүнг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар комиссын нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД